



# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.22. №79 (79)

## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛААРХ МОСКВАГИЙН БАГА ХУРАЛ ХУРАЛДАНА

Олон улсын аюулгүй байдлын талаарх асуудлыг хэлэлцдэг Москвагийн 9 дүгээр бага хурал өнөөдөр эхэлж байна.

Энэ сарын 22-24-ний өдрүүдэд явагдах тус бага хуралд гадаадын 49 орны төлөөлөгчид, түүний дотор Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр урилгаар оролцож байгаа юм.

Хуралд гаднын орны төлөөлөгчдөөс гадна ОХУ-ын гадаад харилцаа, батлан хамгаалах бодлого, аюулгүй байдал судлалын институт, цэргийн академи, их дээд сургуулийн эрдэмтэд, тагнуул, тусгай албад, бусад хүчний байгууллагын удирдлага оролцож илтгэл тавина.

Энэ удаагийн бага хурлаар дэлхийн стратегийн тогтвортой байдал, түүний үнэлгээ, чиг хандлага, үй олноор хөнөөх зэвсэг, мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдал, улс орнуудын зэвсэглэлээр хөөцөлдөж

байгаа асуудал, коронавируст халдварын цар тахлын дэгдэлт, Оросын Африк болон Ойрх Дорнодын орнуудтай харьцах цэрэг-техникийн хамтын ажиллагаа, Европын аюулгүй байдлын асуудлаар хэлэлцэх юм.

ОХУ-ын Батлан хамгаалах яам 2012 оноос жил бүр зохион байгуулж буй уг бага хурлаар ОХУ, бүс нутгийн болон дэлхийн цэрэг-улс төрийн нөхцөл байдлын талаарх сэдвийг өргөн хүрээнд хэлэлцэж, улс орнууд өөрсдийн байр суурь, санал бодлыг солилцдог ба аливаа маргаан зөрчлийг яриа хэлэлцээрийн замаар шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцдог чухал механизм юм.

Тус хурал нь өнгөрсөн долоо хоногт Женев хотод болсон АНУ, ОХУ-ын Ерөнхийлөгч нарын дээд хэмжээний уулзалтын дараахан болж байгаа гэдгээр онцлог болж байна.

Доктор (Ph.D), хурандаа  
Р.ЭНХБОЛД



## ДЭД САЙД Б.БАЯРМАГНАЙГААР АХЛУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ ЗАМЫН-ҮҮДЭД ...



Улсын Онцгой комиссын нэгдсэн хуралдаанаар Дорноговь, Өмнөговь аймгуудад Шуурхай бүлэг томилох асуудлыг хэлэлцэж, улмаар Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнайгаар ахлуулсан ажлын хэсгийг энэ сарын 15-30-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллуулахаар шийдвэрлэлээ.

Ажлын хэсгийн гишүүд дээрх аймгуудыг ногоон бүс болгох, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэх ажлыг зохион байгуулах, экспортыг нэмэгдүүлэхэд үүсч буй хүндрэл саатлыг арилгах, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор ажиллаж байгаа юм.

Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын

Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Г.Гантулга, Гаалийн ерөнхий газрын Статистикийн хэлтсийн дарга Э.Лхагвасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Э.Сарнай, Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга У.Мөнхсансар нар багтжээ.

Өчигдөр ажлын хэсгийнхэн Замын-Үүд суманд ажилласан бөгөөд энэ үеэр Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал тус сумын Онцгой комисс коронавирусийн халдвартай тэмцэх, хариу арга хэмжээг зохион байгуулахад тулгамдаж буй асуудал, цаг үеийн нөхцөл байдлын талаар танилцуулан харилцан санал солилцож, тодорхой асуудлуудыг хэлэлцжээ.

Мөн улс хоорондын ачаа тээвэрлэлт, гаалын хяналтын бүс, боомтын халдваргүйжүүлэлтийн бодит нөхцөл байдлыг шалгаж, үүрэг чиглэл өгсөн байна.

## ТӨВИЙН АЙМГУУДЫН НУТГААР БОРОО ОРНО



Өнөөдөр ихэнх нутгаар үүлшинэ. Төвийн аймгуудын ихэнх нутаг, говийн аймгуудын нутгийн хойд хэсэг, зүүн аймгуудын нутгийн зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орно. Бусад нутгаар бороо орохгүй.

Салхи нутгийн хойд хэсгээр баруун өмнөөс баруун хойш эргэж, бусад нутгаар баруун өмнөөс секундэд 7-12 метр, борооны өмнө түр зуур ширүүснэ.

Агаарын температур Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутаг, Хараа, Ерөө, Туул, Тэрэлж голын хөндийгөөр 18-23 градус, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр 30-35 градус, бусад нутгаар 25-30 градус дулаан байна.

Улаанбаатар хот орчмоор: Үүлэрхэг. Бороо орно. Салхи баруун өмнөөс баруун хойш эргэж секундэд 7-12 метр. 20-22 градус дулаан байна.

Багануур орчмоор: Үүлэрхэг. Бага зэргийн бороо орно. Салхи баруун өмнөөс баруун хойш эргэж секундэд 8-13 метр, борооны өмнө түр зуур ширүүснэ. 21-23 градус дулаан байна.

Тэрэлж орчмоор: Үүлэрхэг. Бага зэргийн аадар бороо орно. Салхи баруун өмнөөс баруун хойш эргэж секундэд 6-11 метр. 21-23 градус дулаан байна.

Өглөө 05 цагт Улаанбаатарт: 17 градус дулаан, харьцангуй чийг 54 хувь, агаарын даралт 864 гектопаскаль байлаа. Даралт өдөртөө тогтвортой байна.

Малчид, иргэд, тариаланчдын анхааралд:

Өнөөдөр төвийн аймгуудын нутгаар бороо, дуу цахилгаантай аадар бороо орох тул үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

ЦАГ АГААР		
УЛААНБААТАР		
ӨДӨР	ШӨНӨ	
22		12
ӨМНӨД СУДАН		
ӨДӨР	ШӨНӨ	
33		24
АФГАНИСТАН		
ӨДӨР	ШӨНӨ	
32		16
ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.442.00	3.484.00
CNY	442.50	446.60
RUB	38.90	40.60
JPY	25.61	26.10
KRW	2.46	2.60

### ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 12  
2021.06.22.  
/МЯГМАР ГАРАГ/

**ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ  
САРЫН ЦАГААН ЦАГААЧИН  
ҮХЭР ӨДӨР**

Үс засуулбал:  
Үс бүү засуул өвчин эмгэг тусах тул муу цээрлэвэл зохилтой.

Наран ургах, шингэх:  
**04:53-20:55**

Барилдлага:  
**Түлэх**

Шүтэн барилдлага:  
**Төрөн түгэхүй**

Суудал:  
**Уул**

Тухайн өдөр Хол газар явагсад баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

-Могой, үхэр, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Харин хонь, бич, тахиа жилтнээ сөрөг муу.

-Шүтээн босгох, тушаал, зарлиг гаргах, хөрөнгө оруулах тэргүүтэн зөвлөн үйл, дайнд ялах, дайсан дарах, номхтоох, цэргийн ба догшин үйл хэрэг, худалдаа хийх, балгас эвдэх, шинэ ноён тавих, захиран тушаах ажил, мал зарах, худалдаа хийх, хот суурин, байшин барилгын суурь тавих, хатуу үйл үүсгэвэл сайн. Элдэв сайн үйлийг эхлэн үүсгэхийг тэвчээс зохистой. Өндөр суудалд сууж эхлэх, туг дарцаг хийсгэх, урлан бүтээх, дархлах, эрдэм ухаанд суралцах, цэрэг хөдөлгөөх, шинэ малгай, хувцас өмсөх, эм найруулах, замд гарах, бэрийн үйл, үхэгсдийн үйл, мал адегуус худалдан авахад муу. Эр хүн хэрэг чирээгдэлд холбогдохоос болоомжилж явах ёстой.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН <b>95.816</b>	ЭДГЭРСЭН <b>63.945</b>	НАС БАРСАН <b>447/11</b>
НИЙТ БАТЛАГДСАН <b>3145(53)</b>	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ <b>368</b>	ЭДГЭРСЭН <b>2725</b>

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 179,245,386

Эдгэрсэн  
Нийт: 163,798,559

Нас барсан  
Нийт: 3,881,890



ЦАХИМ ШУУДАНД

# АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ 810 КИЛОМЕТР ЗАМЫГ ТУУЛААД БАЙНА

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Ховд аймгаас Улаанбаатар хотын чиглэлийн 1500 километр замыг гүйж туулахаар шуударсан Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ахлах ахлагч Э.Даваажамц 20 дахь өдрөө гүйж өчигдөр /11.40 цагийн байдлаар/ 810 километр замыг ардаа орчин Баянхонгор аймгийн төвд

ирлээ. Түүнийг тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Биеийн тамир, спортын газар, Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн удирдлагууд угтан авч амжилт хүслээ.

Ахлах ахлагч Э.Даваажамц энэхүү гүйлтээрээ орчин цагийн Зэвсэгт хүчний 100, ирэх онд

тохиох Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн түүхт 100 жилийн ойд жирийн нэгэн цэргийн алба хаагчийн хувиар бэлэг барьж байгаа юм. Мөн цэргийн алба хаагчдын тэсвэр хатуужил, эр зоригийг олон нийтэд таниулж, цэрэг хүн өмнөө тавьсан зорилгоо хэрхэн биелүүлдгийг харуулахыг зорьжээ.

ДЭЛХИЙД

## АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛД 2,2 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ ЗАРЦУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ӨГЛӨӨ

Доктор (Ph.D), хурандаа Р.ЭНХБОЛД



АНУ-ын Ерөнхийлөгч Жой Байден, тус улсын батлан хамгаалах салбарын төсөвт АНУ Мексикийн хил дээр хана барихаар төлөвлөөд байсан 2,2 тэрбум ам.долларыг шилжүүлж цэргийн бусад төсвийг санхүүжүүлэх зөвшөөрөл өгчээ. Уг мөнгөөр БХЯ нь 11 мужийн нутаг дэвсгэрт

болон гадаадын 16 улс оронд 66 төслийг санхүүжүүлэх ажээ. Тухайлбал, ХБНГУ дахь АНУ-ын цэргийн алба хаагчдын хүүхдүүд сурах дунд сургуулийн барилгыг барихад 79 сая ам.доллар, Хойд Каролина мужид радио батальон шинээр байгуулахад 25 сая ам.доллар, Флорида мужийн нисэх баазыг

засварлахад 25 сая ам.доллар, Аляска муж дахь пуужингийн талбайг өргөтгөхөд 10 сая ам.доллар гэх зэрэг төслүүдэд зарцуулах ажээ. АНУ нь Мексик улстай 3145 километр газраар хиллэдэг бөгөөд өнгөрөгч 4 дүгээр сард америкийн хилийг 178,622 хүн хууль бусаар давж байгаад баригдсан байна. АНУ-ын Ерөнхийлөгч асан Д.Трамп, өмнөд хил дээр хана барих зорилгоор батлан хамгаалах төсвөөс их хэмжээний мөнгө зарцуулсан, мөн зарцуулахаар шийдвэрлээд байсан өмнөх шийдвэрийг одоогийн ерөнхийлөгч өөрчилж байна. Д.Трамп Ерөнхийлөгчөөр ажиллах хугацаандаа нийтдээ 720 километр ханыг шинээр барьсан бөгөөд 2019 онд гэхэд америкийн БХЯ-ны төсвөөс 6,1 тэрбум ам.долларыг хана барихад зарцуулж байв.

/Эх сурвалж: tass.com/

ЦАГ ҮЕ

# ДЭЛХИЙН 23 ОРОН ХҮҮХДҮҮДЭЭ ДАРХЛААЖУУЛЖЭЭ



БНХАУ энэ сард биотехнологийн "Синовак" хүрээлэнгийн хүүхдүүдэд зориулан бүтээсэн цар тахлын эсрэг вакциныг гурваас дээш насны бүх хүүхдэд яаралтай тусламжийн журмаар хийхийг зөвшөөрч, вакцинжуулалтыг даруй эхлүүлсэн билээ. Түүнчлэн тус орны "Кансино" хүрээлэнгийн бүтээсэн хүүхдийн вакцин клиникийн хоёрдугаар шатны туршилтаа хийж байгаа бол "Синофарм" компани хүүхдүүдэд зориулсан вакцины судалгаа хийж эхэлсэн байна. Харин Европын холбоо, АНУ, Канад тэргүүтэй барууны орнуудад Pfizer/BioNTech компанийн бүтээсэн вакциныг 12-оос дээш насны хүүхдүүдэд хийхэд аюулгүйг батлан, хэрэглэж эхэлсэн. Тус компанийн төлөөлөгчдийн мэдээлснээр 5-11 насны хүүхдүүдэд зориулсан вакцины туршилт удахгүй эхлэх бөгөөд энэ онд багтаан зөвшөөрөл авахаар төлөвлөжээ. Түүнээс гадна эрдэмтэд АНУ-ын "Moderna" компанийн бүтээсэн вакциныг 12-оос дээш насныханд аюулгүй хэмээн баталсан тул зөвшөөрөл хүлээж байгаа аж. Гэвч дэлхий даяар олон орон хүүхдүүд байтугай эмч нараа ч вакцинжуулж чадахгүй байгаа тул мэргэжилтнүүд баян орнуудыг илүү вакцинжуулах бусдад хандивлахыг уриалсаар байгаа юм. Бага насны болон өсвөр насны хүүхдүүдэд вакцинжуулж эхэлсэн орнуудыг жагсаан үзвэл: Ази- Номхон далай БНХАУ энэ сарын 5-нд 3-17 насны бүх хүүхдэд "Синовак" хүрээлэнгийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Сингапур энэ сарын 1-нд 12-18 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Япон өнгөрсөн сарын 28-

наас эхлэн 12-оос дээш насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхэлжээ. Филиппин өнгөрсөн сарын 26-наас 12-15 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхэлжээ. Хонгконгийн Засгийн газар "12-оос дээш насныхны вакцинжуулалт удахгүй эхэлнэ" гэжээ. Ойрхи Дорнод Израиль энэ сарын 6-нд 12-15 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Гэхдээ үүнээс өмнө зарим онцгой нөхцөлөөр 16-аас доош насны зарим хүүхдийг вакцинжуулж байсан. Арабын нэгдсэн Эмират улс тавдугаар сарын дундуур Pfizer/BioNTech компанийн вакциныг хүүхдүүдэд тарихыг зөвшөөрсөнд Дубай 12-15 насны өсвөр настнуудаа вакцинжуулж эхэлжээ. Америк АНУ тавдугаар сарын дунд үеэс 12-17 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхэлжээ. Канад тавдугаар сарын эхээр Pfizer/BioNTech компанийн вакциныг 12-15 насны өсвөр настнуудад тарихыг зөвшөөрсөн тул вакцинжуулалтыг даруй эхлүүлсэн байна. Бразил энэ сарын 11-нд 12-оос дээш насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Чили мөн 12-16 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхэлсэн байна. Европын холбоо Франц 12-оос дээш насны өсвөр настнуудыг эцэг, эхийнх нь зөвшөөрлөөр Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхэлжээ.

Герман энэ сарын 10-нд зөвхөн онцгой шаардлагатай хүүхдүүдийг Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулахыг зөвшөөрсөн байна. Итали тавдугаар сарын 31-нд 12-15 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Унгар өнгөрсөн сарын дунд үеэс эхлэн 16-18 насны өсвөр настнуудаа вакцинжуулж буй. Литва энэ сард багтаан 12-оос дээш насны өсвөр настнуудыг дархлаажуулж эхэлнэ гэв. Испани 12-17 насны өсвөр настнуудаа хичээлийн жил эхлэхээс хоёр долоо хоногийн өмнө дархлаажуулж эхлэхээр төлөвлөжээ. Австри наймдугаар сарын сүүл гэхэд 12-15 насны нийт 340 мянган өсвөр настнуудыг вакцинжуулахаар төлөвлөж байна. Эстони энэ оны намраас эхлэн өсвөр настнуудаа дархлаажуулж эхлэхээр төлөвлөж байна. Европын холбооны бус Европын орнууд Нэгдсэн Вант улсын эрх баригчид энэ сарын 16-нд 12-15 насны өсвөр настнуудыг Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулахыг зөвшөөрсөн боловч сайд нар вакцинжуулалтыг эхлүүлэхийн өмнө илүү нарийн судалгаа шаардлагатай хэмээн үзэж байгаа аж. Швейцарь энэ сарын 4-нд 12-15 насны өсвөр настнуудаа Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулж эхлэв. Норвеги цар тахлын халдвар авбал ноцтой хүнд өвчлөх эрсдэлтэй гэж үзсэн хүүхдүүдийг Pfizer/BioNTech компанийн вакцинаар дархлаажуулахаар хэлэлцэж байна. Сан Марино 12-15 насны өсвөр настнуудаа вакцинжуулж эхэлсэн хэмээн эх сурвалжууд мэдээлжээ.

## МАНАЙ ТАМИРЧИД АЙМАГТАА ТЭРГҮҮЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 256 дугаар анги



Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулж байгаа "Дасгал, хөдөлгөөн хийцгээе" хөдөлгөөн Өвөрхангай аймагт өрнөж байна. Зургаадугаар сарын 30-ны өдөр өндөрлөх тус өдөрлөгийн унадаг дугуй, гүйлтийн төрөлд Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн зарим тамирчин тэргүүлж байна.

Тухайлбал, ахлах ахлагч В.Өлзий-Орших 1150, ахлагч Б.Жанчив 1086, Э.Наянжин 985 км зайг туулж, дугуйн төрөлдөө тэргүүлж байгаа бол гүйлтэд ахлах ахлагч Б.Бямбахурал 418, ахлагч Д.Хэнмэдэхүй 360 км замыг туулсан үзүүлэлтээр манлайлсан хэвээрээ байна.

Дэслэгч Э.НОМИН

## ХОТЫН ЗАХИРГААНЫ ШИНЭ БАЙРЫГ "COVID 19"-ИЙН ТҮР ЭМНЭЛЭГ БОЛГОНО



Хотын захиргааны шинэ байрыг "Covid 19"-ийн түр эмнэлэг болгохоор болжээ. Тодруулбал, Яармаг дахь Хотын захиргааны шинэ байранд халдвар авсан жирэмсэн

эхчүүдийг хүлээн авах түр эмнэлэг болгож, яаралтай ор дэлгэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар Нийслэлийн Эрүүл мэндийн

газарт үүрэг болгосон байна. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөр эмнэлгийн орны хүрэлцээний асуудлыг авч хэлэлцжээ. Хуралдаанд Улаанбаатар хотын төвийн бүсийн зургаан дүүргийн удирдлагууд биечлэн, бусад хэлтэс, албадын удирдлагууд цахимаар оролцсон байна. Мөн Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан өчигдөр (2021.06.21) нийслэлийн зургаан дүүрэгт нэмэлтээр 1500 ор дэлгэж, хүчилтөрөгчийн хангамжийг 1000 баллоноор нэмэх талаар мэдээлэв.